

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Отгон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/70/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 70463612 Цахим хаяг: batundraa@audit.gov.mn Ахлах аудитор : Б.Дагвасүрэн Утас:99014227 Цахим хаяг:dagvasurenb@audit.gov.mn Аудитор П.Ганцолмон Утас:70157405 Цахим хаяг:ulistaivanaudit@ubaudit.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал, Шилэн дансны хуулийн хэрэгжилт, бусад хууль тогтоомж	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. Төрийн аудитын санал, дүгнэлт


**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

ОТГОН СУМЫН ЕРӨНИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.ЦЭНД-АЮУШ-д

2022.02.24 № 1002/344
тантай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Отгон сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Отгон сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

010025337

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

МОНГОЛ УЛСЫН
АУДИТ АГУУН

Хүснэгт
2022.02.24

Хүснэгт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
2.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	86,779,498.95	81,802,531.95
33	АВЛАГА	379,992.00	1,631,605.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	721,613.00
335	Бусад авлага	379,992.00	909,992.00
3351	Байгууллагаас авах авлага	379,992.00	909,992.00
35	БАРАА МАТЕРИАЛ	86,399,506.95	80,170,926.95
351	Түүхий эд материал	25,575,259.46	32,251,259.46
35110	Тусгай зориулалттай материал	25,575,259.46	32,251,259.46
354	Хангамжийн материал	60,824,247.49	47,919,667.49
35410	Бичиг хэргийн материал	536,650.00	868,000.00
35420	Аж ахуйн материал	4,913,936.00	5,237,136.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	-
35440	Түлш, шатах тослох материал	8,232,160.00	1,800,000.00
35450	Барилгын засварын материал	2,174,000.00	-
35460	Хүнсний материал	15,701,790.00	8,141,320.00
35470	Бусад хангамжийн материал	29,265,711.49	31,873,211.49
2	ЭРГЭЛТИЙН БҮС ХӨРӨНГИЙН ДҮН	1,471,333,647.31	1,401,457,569.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,471,333,647.31	1,401,457,569.35
392	Биет хөрөнгө	1,403,486,147.31	1,333,940,069.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,428,298,821.46	1,427,640,093.46
39202	Хуримтлагдсан элэгдэл	(155,531,874.64)	(200,437,306.36)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,350,000.00	30,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(21,350,000.16)	(25,000,000.20)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	190,482,895.35	195,113,895.35
39206	Хуримтлагдсан элэгдэл	(143,499,473.98)	(160,419,013.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	102,544,416.33	105,544,016.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	(76,708,317.87)	(84,372,844.75)
39214	Бусад үндсэн хөрөнгө	42,297,466.36	40,897,466.36
39215	Хуримтлагдсан элэгдэл	(21,534,688.52)	(26,518,855.20)
39217	Ном	27,136,902.98	31,492,617.98
393	Биет бус хөрөнгө	67,847,500.00	67,517,500.00
39301	Програм хангамж	2,505,000.00	2,505,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,047,500.00)	(1,377,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	66,390,000.00	66,390,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	1,558,113,146.26	1,483,260,101.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.01	0.01
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.01	0.01
413	Өг лөг	0.01	0.01
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.01	0.01
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,558,113,146.26	1,483,260,101.30
51	Засгийн газрын хувь оролцоо	1,558,113,146.26	1,483,260,101.30
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	353,242,457.52	353,242,457.52
51101	Өмч: - төрийн	353,242,457.52	353,242,457.52
512	Хуримтлагдсан үр дүн	1,008,038,452.37	933,733,735.41
51210	Өмнөх үеийн үр дүн	1,008,038,452.37	1,008,586,780.37
51220	Тайлант үеийн үр дүн	-	(74,853,044.96)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	196,832,236.37	196,283,908.37
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V	1,558,113,146.27	1,483,260,101.31

2.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	962,561,061.57	902,896,940.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	76,989,653.57	14,706,715.00
120	Нийтлэг татварын бус орлого	76,989,653.57	14,706,715.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	76,989,653.57	14,706,715.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	76,989,653.57	14,706,715.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	885,571,408.00	888,190,225.64
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	822,108,100.00	812,740,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	822,108,100.00	812,740,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,280,808.00	18,441,425.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,280,808.00	18,305,425.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	-	136,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	59,182,500.00	57,008,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,182,500.00	57,008,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	942,334,813.27	977,486,494.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	942,334,813.27	977,486,494.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	876,045,896.56	940,232,602.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	627,442,820.00	660,309,768.00
210101	Үндсэн цалин	440,871,658.00	418,897,758.00
210102	Нэмэгдэл	138,858,981.00	188,568,962.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	47,712,181.00	52,843,048.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,623,762.00	87,420,719.00
210201	Тэтгэврийн даатгал	52,415,062.00	61,043,919.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,727,000.00	6,594,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,381,600.00	5,275,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,646,100.00	1,318,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,454,000.00	13,188,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,121,899.29	62,807,000.00
210301	Гэрэл, цахилгаан	5,063,999.29	4,599,500.00
210302	Тулш, халаалт	50,882,900.00	56,194,500.00
210303	Цэвэр, бохир ус	175,000.00	2,013,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,508,330.00	7,930,173.64
210401	Бичиг хэрэг	1,925,500.00	1,897,913.64
210402	Тээвэр, шатахуун	760,900.00	2,552,960.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,063,700.00	305,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариунгал	212,800.00	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,545,430.00	2,774,200.00

2105	Нормативт зардал	18,899,640.00	29,939,540.00
210501	Эм, бээлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,099,050.00	1,000,000.00
210502	Хоол, хүнс	17,800,590.00	28,939,540.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	3,674,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	3,674,000.00
2107	Томилолт, зочны зардал	300,000.00	1,930,600.00
210702	Дотоод албан томилолт	300,000.00	1,930,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	854,128.00	800,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	854,128.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,795,317.27	85,420,801.76
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,988,000.00	3,821,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хөрогдол	78,807,317.27	81,598,901.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,288,916.71	37,253,892.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,780,808.00	36,897,692.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	22,985,430.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан	4,280,808.00	13,412,262.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	356,200.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	356,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	61,508,108.71	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	61,508,108.71	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	20,226,248.30	(74,589,553.76)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	263,491.20
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	263,491.20
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(263,491.20)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	20,226,248.30	(74,853,044.96)

2.3 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	353,242,457.52	196,832,236.37	987,812,204.07	1,537,886,897.96
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин үнэлэхийлсэн үлдэгдэл	353,242,457.52	196,832,236.37	987,812,204.07	1,537,886,897.96
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	20,226,248.30	20,226,248.30
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	353,242,457.52	196,832,236.37	1,008,038,452.37	1,558,113,146.26
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	353,242,457.52	196,832,236.37	1,008,038,452.37	1,558,113,146.26
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	548,328.00	548,328.00
D03	Дахин үнэлэхийлсэн үлдэгдэл	353,242,457.52	196,832,236.37	1,008,586,780.37	1,558,661,474.26
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(548,328.00)	-	(548,328.00)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(74,853,044.96)	(74,853,044.96)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	353,242,457.52	196,283,908.37	933,733,735.41	1,483,260,101.30

2.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	885,571,408.00	888,190,225.64
13	ГУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	885,571,408.00	888,190,225.64
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	822,108,100.00	812,740,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	822,108,100.00	812,740,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,280,808.00	18,441,425.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,280,808.00	18,305,425.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	136,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	59,182,500.00	57,008,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,182,500.00	57,008,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	878,750,958.00	883,924,325.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	878,750,958.00	883,924,325.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	801,981,191.29	850,552,863.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшлал	627,442,820.00	659,429,500.00
210101	Үндсэн цалин	440,871,658.00	418,017,490.00
210102	Нэмэгдэл	138,858,981.00	188,568,962.00
210104	Урамшуулал	47,712,181.00	52,843,048.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,623,762.00	89,022,600.00
210201	Тэтгэврийн даатгал	52,415,062.00	62,645,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,727,000.00	6,594,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,381,600.00	5,275,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,646,100.00	1,318,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,454,000.00	13,188,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,508,499.29	55,508,500.00
210301	Гэрэл, цахилгаан	5,063,999.29	5,129,500.00
210302	Түлш, халаалт	50,269,500.00	48,366,000.00
210303	Цэвэр, бохир ус	175,000.00	2,013,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,414,010.00	9,834,763.64
210401	Бичиг хэрэг	2,068,500.00	2,229,263.64
210402	Тээвэр, шатахуун	4,394,060.00	3,949,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,063,700.00	305,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	212,800.00	400,000.00
210406	Бага үнэтэй, тургэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,674,950.00	2,951,100.00
2105	Нормативт зардал	19,712,800.00	27,668,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,099,050.00	1,000,000.00
210502	Хоол, хувц	16,213,750.00	25,261,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,400,000.00	1,406,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,674,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	3,674,000.00	1,500,000.00
2107	Томилголт, зочны зардал	300,000.00	1,930,600.00
210702	Дотоод албан томилолт	300,000.00	1,930,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,194,500.00	800,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,194,500.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,110,800.00	4,858,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,110,800.00	4,858,800.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,769,766.71	33,371,462.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,261,658.00	33,015,262.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,480,850.00	19,103,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,280,808.00	13,412,262.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	356,200.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	356,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	61,508,108.71	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	61,508,108.71	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6,820,450.00	4,265,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,723,200.00	4,265,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,723,200.00	4,265,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,723,200.00	4,265,900.00
225106	Биег ба биег бус хөрөнгө худалдан авсан зардал	6,723,200.00	4,265,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(6,723,200.00)	(4,265,900.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	97,250.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	869,680,300.00	869,392,600.00	287,700.00	100%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	869,680,300.00	869,392,600.00	287,700.00	100%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧЛЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	860,077,300.00	849,789,600.00	287,700.00	100%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	659,682,700.00	659,429,500.00	253,200.00	100%
210101	Үндсэн цалин	468,610,700.00	418,017,490.00	50,593,210.00	89%
210102	Нэмэгдэл	152,248,500.00	188,568,962.00	(36,320,462.00)	124%
210104	Урамшуулал	38,823,500.00	52,843,048.00	(14,019,548.00)	136%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,057,100.00	89,022,600.00	34,500.00	100%
210201	Тэтгэврийн даатгал	62,669,900.00	62,645,800.00	24,100.00	100%
210202	Тэтгэмжийн даатгал	6,596,800.00	6,594,200.00	2,600.00	100%
210203	ҮОМШЭ-ний даатгал	5,277,500.00	5,275,300.00	2,200.00	100%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,319,300.00	1,318,900.00	400.00	100%
210205	Эрүүл мэндийн даатгал	13,193,600.00	13,188,400.00	5,200.00	100%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,508,500.00	55,508,500.00	-	100%
210301	Гэрэл, цахилгаан	14,494,600.00	5,129,500.00	9,365,100.00	35%
210302	Түлш, халаалт	39,223,500.00	48,366,000.00	(9,142,500.00)	123%
210303	Цэвэр, бохир ус	1,790,400.00	2,013,000.00	(222,600.00)	112%
2104	Хангамж, бараа материалын зардал	9,966,000.00	9,966,000.00	-	100%
210401	Бичиг хэрэг	1,379,000.00	1,985,600.00	(606,600.00)	144%
210402	Тээвэр, шатахуун	3,946,300.00	3,949,300.00	(3,000.00)	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	305,100.00	494,900.00	38%
210404	Ном, хэвлэл	2,068,500.00	374,900.00	1,693,600.00	18%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	400,000.00	(400,000.00)	
210406	Бага үнэтэй, гургэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,772,200.00	2,951,100.00	(1,178,900.00)	167%
2105	Нормативт зардал	27,668,100.00	27,668,100.00	-	100%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,000,000.00	1,000,000.00	-	100%
210502	Хоол, хүнс	25,261,500.00	25,261,500.00	-	100%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,406,600.00	1,406,600.00	-	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00	-	100%
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00	-	100%
2107	Томилголт, зочны зардал	1,930,600.00	1,930,600.00	-	100%
210702	Дотоод албан томилголт	1,930,600.00	1,930,600.00	-	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	800,000.00	800,000.00	-	100%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00	-	100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3964300.00	3964300.00	-	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,964,300.00	3,964,300.00	-	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19603000.00	19603000.00	-	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,603,000.00	19,603,000.00	-	100%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	19,103,000.00	19,103,000.00	-	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00	-	100%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	869,797,500.00	869,748,800.00	48,700.00	100%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	812,789,000.00	812,740,300.00	48,700.00	100%
131001	Улсын төсвөөс санхүүжих	812,789,000.00	812,740,300.00	48,700.00	100%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	57,008,500.00	57,008,500.00	-	100%
132001	Орон нутгийн төсвөөс	57,008,500.00	57,008,500.00	-	100%

2.6 Аудит хийсэн Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18,441,425.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	18,441,425.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,029,163.64
2104	Хавгамж, бараа материалын зардал	243,663.64
210401	Бичиг хэрэг	243,663.64
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,785,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,785,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,412,262.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,412,262.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,412,262.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	18,441,425.64
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,441,425.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,305,425.64
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	136,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Отгон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллага Отгон сумын Ерөнхий боловсролын сургуультай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улиастай ван аудит ХХК-ийн ахлах аудитор П.Ганцолмон, аудитор Д.Гэрэлхүү нар гүйцэтгэж, ахлах аудитор Б.Дагвасүрэн, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Отгон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Отгон сумын Ерөнхий боловсролын сургууль нь Суралцагч бүрийг боловсролд тэгш боломжоор хангах, хүүхэд бүрийн онцлог ялгаатай хэрэгцээнд тулгуурлан сурах, хөгжих үйлийг дэмжиж, хамтран суралцах соёлыг төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрддөггүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Отгон сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 6,100.0 мянган төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 70 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 422,800.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,200.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,900.0 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Авлага	379.9	1,631.6	1,251.7
Бараа	86,399.5	80,170.9	-6,228.6
Үндсэн хөрөнгө	1,471,333.6	1,402,457.5	-68,876.1
Нийт хөрөнгө	1,558,113.0	1,484,260.0	-73,853.0
Өр төлбөр			-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,558,113.0	1,484,260.0	-73,853.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө	1,558,113.0	1,484,260.0	-73,853.0

Авлага дансны нь үлдэгдэл өмнөх оноос 1,251.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь байгууллагаас авах авлага, ажиллагчидтай холбогдсон авлага тайлант хугацаанд нэмэгдсэн мөн өмнөх оны бусад зардлын тооцооны авлагыг барагдуулаагүй байдлаас үүдэн нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 6,228.6 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 109,179.6 мянган төгрөг, хандивын хөрөнгөөр 6,986.3 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус олж бэлтгэн, 122,394.5 мянган төгрөгийн зарцуулалт хийсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 68,876.1 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 4,265.9 мянган төгрөг, хандивын хөрөнгөөр 7,720.4 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус олж бэлтгэсэн.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 73,853.0 мянган төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 869,680.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 869,392.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж батлуулсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 57,008.5 мянган төгрөгийн, улсын төсвөөс 812,740.3 мянган төгрөгийн, нийт 869,748.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 869,392.6 мянган төгрөгийг зарцуулж, 356.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар өөрийн орлого 136.0 мянган төгрөг, орон нутгийн санхүүжилт 18,305.4 мянган төгрөг, нийт 18,441.4 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласаны тэтгэмж 13,412.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 5,029.1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. Төвлөрүүлсэн орлого байхгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллээс 132 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон мэдээлэл 6, оруулаагүй 3 мэдээлэл хугацаа болоогүй 5 мэдээлэл байна.

Хугацаа хоцорсон мэдээлэл нь 10 дугаар сарын 5,000.0 мянган төгрөгнөөс дээш үнийн дүнтэй гүйлгээний мэдээлэл мөн 2021 оны батлагдсан төсвийг дараа оны 1 дүгээр сарын 10-ний дотор байршуулах мэдээлэл хугацаа хоцорч мэдээлсэн байсан.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Отгон сумын Ерөнхий Боловсролын Сургууль-д “Зөрчилгүй дүгнэлт”-ээр 1 зөвлөмж өгснийг биелүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улирал бүр албан хаагчдад Тушаалаар олгож байгаа үр дүнгийн урамшуулалын биелэлтийг тооцож, удирдлагын зүгээс санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Шатахууны тооцоог сар бүр бодож хэвших.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,914.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 600.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 6,313.8 мянган төгрөгийн зөрчилд акт хүргүүлж, нийт алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Гарын үсэггүй замын хуудас, жолоочийн тооцоог бодож 600.2 мянган төгрөгт залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт: Албан хаагчдад ажил дүгнэж олгох тушаалаар баталгаажсан үр дүнгийн урамшууллыг нөхөн тооцож олгох 5,694,5 мянган төгрөг, илүү олгосон үр дүнгийн урамшуулал 619.3 мянган төгрөгийг суутган тооцох нийт 6,313.8 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага хүргүүлээгүй.

4.4 Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Отгон сумын Ерөнхий боловсролын сургууль	3	6.9	1	0.6	2	6.3	-	-	-	-